



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/276/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Тэмүүжин Утас: 325093 Цахим хаяг: temuujing@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 135
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Н.БАТТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 98.2 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Аудит хийсэн 2025 оны санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	615,247,824.56	855,317,630.68
33	АВЛАГА	21,407,085.86	27,310,531.39
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	677,802.19	277,372.39
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	6,533,238.67	12,837,114.00
335	Бусад авлага	14,196,045.00	14,196,045.00
3351	Байгууллагаас авах авлага	14,196,045.00	14,196,045.00
34	УРЬДЧИЛГАА	00.00	3,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	3,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	593,840,738.70	825,007,099.29
351	Түүхий эд материал	00.00	231,206,102.50
35110	Тусгай зориулалттай материал	00.00	224,967,450.00
35130	Эм боох материал	00.00	6,238,652.50
354	Хангамжийн материал	593,840,738.70	593,800,996.79
35410	Бичиг хэргийн материал	1,544,740.00	2,106,235.00
35420	Аж ахуйн материал	546,242,401.00	420,671,749.13
35430	Сэлбэг хэрэгсэл	4,856,200.00	7,973,750.00
35440	Түлш, шатах тослох материал	2,170,000.00	11,018,640.00
35450	Барилгын засварын материал	00.00	2,958,840.00
35460	Хүнсний материал	11,444,897.70	66,190,812.66
35470	Бусад хангамжийн материал	27,582,500.00	82,880,970.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	377,091,957.95	1,503,752,515.88
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	377,091,957.95	1,503,752,515.88
392	Биет хөрөнгө	377,033,291.37	1,503,752,515.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	26,914,800.00	26,914,800.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-13,831,840.00	-16,124,020.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	70,300,000.00	70,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-43,440,277.59	-65,644,444.33
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	683,187,184.50	1,677,636,135.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-506,026,801.75	-513,972,962.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	377,743,748.55	521,708,483.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-217,813,522.34	-207,826,271.25
39214	Бусад үндсэн хөрөнгө	128,085,749.00	37,139,050.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-128,085,749.00	-26,378,254.14
393	Биет бус хөрөнгө	58,666.58	00.00
39301	Програм хангамж	776,000.00	776,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-717,333.42	-776,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	992,339,782.51	2,359,070,146.56
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,850,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,850,000.00
413	Өглөг	00.00	2,850,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	850,000.00
4136	Бусад өглөг	00.00	2,000,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	2,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	992,339,782.51	2,356,220,146.56
51	Засгийн газрын хувь оролцоо	992,339,782.51	2,356,220,146.56
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	8,463,102,139.75	8,463,102,139.75

51101	Өмч: - төрийн	8,463,102,139.75	8,463,102,139.75
512	Хуримтлагдсан үр дүн	-7,470,762,357.24	-6,106,881,993.19
51210	Өмнөх үеийн үр дүн	-7,470,762,357.24	-7,470,762,357.24
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,363,880,364.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	992,339,782.51	2,359,070,146.56

Аудит хийсэн 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	12,902,706,472.80	16,485,431,372.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,623,212,414.14	2,741,956,078.45
120	Нийтлэг татварын бус орлого	1,623,212,414.14	2,741,956,078.45
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,623,212,414.14	2,741,956,078.45
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	387,334,496.40	384,166,871.43
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,140,671,970.21	1,033,368,977.02
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	95,205,947.53	1,265,583,230.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	0.00	58,837,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,279,494,058.66	13,743,475,294.19
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	480,741,241.75	454,183,339.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	299,279,314.00	454,183,339.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	181,461,927.75	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,798,752,816.91	13,289,291,955.19
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,798,752,816.91	13,289,291,955.19
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13,113,383,094.87	15,121,551,008.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,113,383,094.87	15,121,551,008.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,945,246,369.14	14,996,584,497.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,891,786,364.74	9,299,311,389.77
210101	Үндсэн цалин	3,550,142,236.01	4,561,570,447.48
210102	Нэмэгдэл	1,431,171,812.76	1,858,822,642.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,395,170,025.80	2,166,815,000.00
210104	Урамшуулал	515,302,290.17	712,103,299.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	892,464,407.65	1,163,770,691.80
210201	Тэтгэврийн даатгал	604,006,365.89	785,324,877.62
210202	Тэтгэмжийн даатгал	70,991,796.07	94,609,779.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	56,482,754.06	84,392,348.17
210204	Ажилгүйдлийн даатгал	32,169,588.15	39,888,737.68
210205	Эрүүл мэндийн даатгал	128,813,903.48	159,554,948.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,592,646,829.60	1,538,098,953.20
210301	Гэрэл, цахилгаан	960,758,294.06	1,054,621,184.22
210302	Түлш, халаалт	384,805,928.58	288,203,076.26
210303	Цэвэр, бохир ус	247,082,606.96	195,274,692.72
2104	Хангамж, бараа материалын зардал	740,552,505.87	751,034,730.52
210401	Бичиг хэрэг	8,881,930.33	10,302,704.00
210402	Тээвэр, шатахуун	55,183,015.00	42,337,195.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,528,720.54	12,799,591.21
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	48,898,000.00	48,448,119.44
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	543,619,930.00	432,391,610.87
210408	Бараа материал акталсны зардал	71,440,910.00	204,755,510.00
2105	Нормативт зардал	1,283,871,994.11	1,152,873,710.53
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,014,865.00	338,526.50

210502	Хоол, хүнс	1,281,857,129.11	1,152,535,184.03
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	408,282,781.76	349,606,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	2,923,465.00
210604	Урсгал засвар	408,282,781.76	346,682,635.00
2107	Томилолт, зочны зардал	11,814,000.00	00.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	11,814,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	255,507,328.27	270,761,117.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	253,668,328.27	266,887,117.20
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,000.00	600,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	108,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,660,000.00	3,166,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	868,320,157.14	471,127,804.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	364,054,275.85	285,337,172.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	3,094,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	504,265,881.29	182,696,632.07
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	168,136,725.73	124,966,511.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	163,624,573.73	120,798,907.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	114,829,573.73	82,829,725.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,795,000.00	37,969,182.50
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	426,452.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,085,700.00	4,167,604.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,085,700.00	4,167,604.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,883,330.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,883,330.00	00.00
223001	Бусад хөрөнгө	27,883,330.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-238,559,952.07	1,363,880,364.05
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	12,432,772,246.01	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	12,432,772,246.01	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-12,432,772,246.01	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-12,671,332,198.08	1,363,880,364.05

Аудит хийсэн 2025 оны мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	12,812,818,540.43	15,163,038,956.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,533,324,481.77	1,419,563,662.45
120	Нийтлэг татварын бус орлого	1,533,324,481.77	1,419,563,662.45
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,533,324,481.77	1,419,563,662.45
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	388,065,485.92	382,279,255.43
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,145,258,995.85	1,037,284,407.02
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,279,494,058.66	13,743,475,294.19
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	480,741,241.75	454,183,339.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	299,279,314.00	454,183,339.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	181,461,927.75	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,798,752,816.91	13,289,291,955.19

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,798,752,816.91	13,289,291,955.19
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	12,741,944,607.48	15,119,264,996.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,741,944,607.48	15,119,264,996.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,560,138,631.75	14,989,859,485.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,846,345,509.19	9,304,686,160.56
210101	Үндсэн цалин	3,503,218,546.85	4,442,943,408.75
210102	Нэмэгдэл	1,428,806,261.60	1,985,188,730.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,391,979,455.67	2,166,975,667.54
210104	Урамшуулал	522,341,245.07	709,578,353.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	944,715,474.40	1,164,327,180.54
210201	Тэтгэврийн даатгал	661,243,658.92	805,116,943.16
210202	Тэтгэмжийн даатгал	71,309,163.38	95,896,569.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	59,381,754.43	64,458,072.59
210204	Ажилгүйдлийн даатгал	24,067,626.18	38,421,188.81
210205	Эрүүл мэндийн даатгал	128,713,271.49	160,434,406.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,592,068,207.60	1,531,781,030.74
210301	Гэрэл, цахилгаан	960,074,071.30	1,054,621,184.22
210302	Түлш, халаалт	379,345,154.46	279,745,476.04
210303	Цэвэр, бохир ус	252,648,981.84	197,414,370.48
2104	Хангамж, бараа материалын зардал	708,983,885.87	798,771,443.65
210401	Бичиг хэрэг	8,117,530.00	6,381,652.00
210402	Тээвэр, шатахуун	36,171,815.00	54,363,695.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,822,320.87	13,696,971.21
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	48,748,000.00	49,343,119.44
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	603,124,220.00	674,986,006.00
2105	Нормативт зардал	1,295,193,001.18	1,238,318,795.65
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,164,865.00	5,676,684.00
210502	Хоол, хүнс	1,275,312,336.18	1,217,090,611.65
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,715,800.00	15,551,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	455,141,371.76	381,021,135.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	16,773,300.00	10,029,960.00
210604	Урсгал засвар	438,368,071.76	370,991,175.00
2107	Томилолт, зочны зардал	48,617,275.75	00.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	48,617,275.75	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	327,328,792.00	305,121,005.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	324,719,792.00	293,010,105.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,000.00	600,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	108,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,430,000.00	11,402,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	341,745,114.00	265,832,734.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	341,745,114.00	262,738,734.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	3,094,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	181,805,975.73	129,405,511.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	177,293,823.73	125,237,907.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	114,829,573.73	82,829,725.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	62,464,250.00	42,408,182.50
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,512,152.00	4,167,604.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,085,700.00	4,167,604.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	70,873,932.95	43,773,960.00

	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	72,491,956.00	43,773,960.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	72,491,956.00	43,773,960.00
2200	Дотоод эх үүсвэрээр	72,491,956.00	43,773,960.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	72,491,956.00	43,773,960.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-72,491,956.00	-43,773,960.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-1,618,023.05	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,618,023.05	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

Аудит хийсэн 2025 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,463,102,139.75	6,450,248,485.66	-1,198,429,934.82	00.00	13,714,920,690.59
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	6,398,999,775.66	00.00	6,398,999,775.66
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,463,102,139.75	6,450,248,485.66	5,200,569,840.84	00.00	20,113,920,466.25
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-6,450,248,485.66	00.00	00.00	-6,450,248,485.66
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	12,671,332,198.08	00.00	-12,671,332,198.08
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,463,102,139.75	00.00	-7,470,762,357.24	00.00	992,339,782.51
D01	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,463,102,139.75	00.00	-7,470,762,357.24	00.00	992,339,782.51
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,463,102,139.75	00.00	-7,470,762,357.24	00.00	992,339,782.51
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,363,880,364.05	00.00	1,363,880,364.05
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,463,102,139.75	00.00	-6,106,881,993.19	00.00	2,356,220,146.56

Аудит хийсэн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,500,438,000.00	14,704,688,013.64	2,795,749,986.36	84.0%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,500,438,000.00	14,704,688,013.64	2,795,749,986.36	84.0%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,363,608,200.00	14,579,450,106.14	2,784,158,093.86	84.0%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,220,522,500.00	9,304,686,160.56	915,836,339.44	91.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,277,565,300.00	1,164,327,180.54	113,238,119.46	91.1%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,386,374,400.00	1,531,781,030.74	854,593,369.26	64.2%
2104	Хангамж, бараа материалын зардал	1,078,383,900.00	798,771,443.65	279,612,456.35	74.1%
2105	Нормативт зардал	1,356,907,800.00	1,223,318,795.65	133,589,004.35	90.2%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	634,104,300.00	421,240,595.00	212,863,705.00	66.4%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	402,200,000.00	132,230,900.00	269,969,100.00	32.9%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,550,000.00	3,094,000.00	4,456,000.00	41.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,550,000.00	3,094,000.00	4,456,000.00	41.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	136,829,800.00	125,237,907.50	11,591,892.50	91.5%
2132	Бусад урсгал шилжүүлэг	136,829,800.00	125,237,907.50	11,591,892.50	91.5%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	82,829,800.00	82,829,725.00	75.00	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	54,000,000.00	42,408,182.50	11,591,817.50	78.5%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	18,021,267,800.00	14,704,688,013.64	3,316,579,786.36	81.6%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,953,876,700.00	13,285,124,351.19	1,668,752,348.81	88.8%
132001	Орон нутгийн төсвөөс	14,953,876,700.00	13,285,124,351.19	1,668,752,348.81	88.8%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,067,391,100.00	1,419,563,662.45	1,647,827,437.55	46.3%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	542,763,300.00	382,279,255.43	160,484,044.57	70.4%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,524,627,800.00	1,037,284,407.02	1,487,343,392.98	41.1%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	499.00	297.00	202.00	59.5%
620001	Удирдах ажилтан	05.00	04.00	01.00	80.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	489.00	290.00	199.00	59.3%
620003	Үйлчлэх ажилтан	05.00	03.00	02.00	60.0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	499.00	297.00	202.00	59.5%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	01.00	01.00	00.00	100.0%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	498.00	296.00	202.00	59.4%

Аудит хийсэн 2025 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	454,183,339.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	454,183,339.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	454,183,339.00

2105	Нормативт зардал	15,000,000.00
210502	Хоол, хүнс	15,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,554,500.00
210604	Урсгал засвар	3,554,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	172,890,105.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	172,890,105.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	262,738,734.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	262,738,734.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	454,183,339.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	454,183,339.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	454,183,339.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Илрүүлэлт: Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 88,568.9 мянган төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй, бусад холбогдох мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх," 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" 6.4.9-д "хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл;" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өглөө.

Илрүүлэлт: Тайлант онд холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах цахим системд хүсэлт илгээж худалдан авалт хийгээгүй, төсөвт өртгийг хувааж тендер зарлаагүй нэг байгууллагаас 23,065.9 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "ерөнхий гэрээний арга" гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг"; 9 дүгээр зүйлийн 9.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ" 38 дугаар зүйлийн 38.1-т "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна," гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант онд холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн худалдан авах цахим системд хүсэлт илгээж худалдан авалт хийгээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар нийт 177,125.6 мянган төгрөгийн зөрчил¹¹ илэрснээс, алдаа зөрчлийг арилгах 177,125.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөв.

Илрүүлэлт-1: Он дамжсан 14,196.0 мянган төгрөгийн авлагыг тайлант онд барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх;" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Он дамжсан авлагыг барагдуулах төлөвлөгөө гаргаж арга хэмжээ авч ажиллах.

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртөө нөхсөн 4 нэр төрлийн 162,929.6 мянган төгрөгийн хөрөнгүүдийн ашиглагдах хугацааг сунгаж дахин үнэлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" 12 дугаар зүйлийн 12.2-т "хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72, 73 дугаар зүйлийн холбогдох заалт;" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өсөн зөвлөмж: Үлдэх өртөггүй хөрөнгүүдийг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэх, эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлэх зөвлөмж өглөө.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр /

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ННУГ	1	14.2	-	-	-	-	1	14.2	-	-	-	-
	1	162.9	-	-	-	-	1	162.9	-	-	-	-
Дүн	2	177.1	-	-	-	-	2	177.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр /

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ННУГ	1	88.6	-	-	-	-	1	88.6
Дүн	1	88.6	-	-	-	-	1	88.6
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ННУГ	1	23.1	-	-	1	23.1	-	-
Дүн	1	23.1	-	-	1	23.1	-	-
Нийт дүн	2	111.7	-	-	1	23.1	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

/сая төгрөгөөр /

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1	-	-	-
	НИЙТ	1	1	-	-	1	-	-	-